

**7 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ****Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

ЗДТГ-ын албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийн дагуу албан хаагчдын ээлжийн амралтыг өгөөд байна. Хагас жилийн сумын үйл ажиллагааны тайланг цахим системд тайлагнасан. ТАХ-дын хагас жилийн гүйцэтгэлийн үр дүнг үнэлж дүгнэсэн. Нийт ТЗ-ны 7 албан хаагч, ТҮ-ний 8 албан хаагчид урамшуулал олгосон.

**Хоёр: Нийгмийн бодлогын хүрээнд:**

Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд сумын дүнгээр нийт 72 өрхийн төсөл ирснээс амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцэгдээд 27 өрхийг сонгож аймгийн Засаг даргын шийдвэрээр малжуулах хөтөлбөрт хамруулсан. Сумын хэмжээнд 27 өрхөд малжуулах арга хэмжээний 216,0 сая төгрөгийн санхүүжилтээр малжуулсан.

**Ерөнхий боловсролын сургууль:** 2023-2024 оны хичээлийн жил нь манай сургуулийн хувьд сургуулийн түүхт 100 жилийн ой 8 сарын 2,3 нд болохтой холбогдуулан бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж байна., “ЭЕШ-2024”-д сурагчид маань амжилттай шалгагдлаа. “ЭЕШ-2024” Монгол хэл, Математик, Хими, Физик, Англи хэл, Нийгмийн ухаан, Биологи, Газарзүй зэрэг хичээлүүдээр шалгалт өгч тус тус амжилт гаргасан бөгөөд 12а ангийн сурагч А.Өнөмөнх Математик, Физик, Монгол хэл, Англи хэл гэсэн 4-н хичээл тус бүрд амжилттай дүн үзүүлэн сургуулийн шилдэг төгсөгчөөр шалгарлаа.

“ЭЕШ-2024” Талархлын баярыг Сүхбаатар-Нэг мөрөөдөл ТББ, БШУГ хамтран зохион байгуулж судлагдахуун тус бүрээр аймагтаа голч оноогоороо тэргүүлсэн хичээлүүдийн бэлтгэсэн багш нарыг шагнаж урамшуулсан. Үүнд тус сургуулийн МХУЗ-ын багш А.Даваасүрэн 12 сурагчийг амжилттай бэлтгэн улс, аймгийн дунджаас дээш амжилт гарган улмаар аймагтаа ТЭРГҮҮН байр эзлэж, ЭЕШ-ын шилдэг багш шагналын эзэн боллоо.

Сургуулийн түүхт 100 жилийн ойн ажлын хүрээнд сургууль болон дотуур байранд орчин үеийн ариун цэврийн байгууламжийг 2.2 тэр бум төгрөгийн санхүүжилтээр Модерн хас ХХК хийж гүйцэтгэж байна. Орон нутгийн хөгжлийн сангаас 120 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сургуулийн дотор засал, шалны их засварыг хийж гүйцэтгэж байна. Мөн сурагчдын дотуур байранд их засвар, анги даасан багш нар анги танхимдаа их засвар, гадаа талбайн тохижилт, их засварыг төгсөгчдийн хандив дэмжлэгээр тус тус хийж гүйцэтгэж байна.

**Эрүүл мэндийн чиглэлээр****Соёлын төв:****НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

Номын сангийн танхимын үйлчилгээгээр 68 иргэд, хүүхэд багачуудад 31нэр төрлийн 87 ширхэг номоор үйлчилсэн байна. 2024 оны номын сангийн /Lib4u/ цахим номын шивэлтын ажлыг хийж дуусгаж шинээр ирсэн уран зохиол, түүх роман, хүүхдийн үлгэрийн ном, тууж гэх мэт төрөлжсөн номыг бүртгэлд кодлон оруулсан.

ЕБС-ын дунд ахлах ангийн сурагчид мэргэжил сонгох шалгалтын бэлтгэл хангах номын сангаас өөрт хэрэгтэй номоо картаар авч уншлагын танхимд шалгалтандаа бэлдэж Ахлах ангийн 2 бүлгийн нийт 58 хүүхэд үйлчлүүлсэн.

### **СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Иргэдийн гар дээрх өвийг бүртгэн мэдээллийн санд бүртгэж байна. Соёлын өвийн чиглэлээр бүртгэгдсэн газруудад очиж судалгаа хийлээ. **ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

2024 оны 07-р сард бүжгийн дугуйлан 79 сурагчтайгаар нийт 10 удаагийн 20 цагийн сургалтыг зохион байгуулан ардын бүжгийн дасгал сонгодог бүжгийн дасгалыг зааж сургаж байна. Мөн дугуйлангийн сурагчид насны ангиллаар хамтлаг гарган шинэлэг бүжгүүдийг дэглэж олон шинэ бүжгүүдтэй болсон. Баяр наадмын нээлтийн үйл ажиллагаанд дугуйлангийн 79 сурагчид болон нэмэлт элсэлт авч нийт 118 сурагчид нээлтэнд оролцож бүжиглэсэн. Баяр наадмын 101 жилийн ойд зориулан 3 шинэ бүжиг дэглэн гаргасан Мөн сургуулийн түүхт 100 жилийн ойн хүндэтгэлийн тоглолт, нээлтийн арга хэмжээний бүжгэнд дугуйлангийн сурагчид бэлтгэл хийж байна.

### **СОЁЛЫН ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР:**

Соёлын төвийн гаднах хаягжуулалтыг монгол бичгийн гэрлэн хаягтай болгосон. Баяр наадмын нээлтийн үйл ажиллагаанд төрийн албан хаагчид, ахмадууд болон дугуйлангийн сурагчдын жагсаалыг зохион байгуулж ажилласан. Нээлтийн арга хэмжээнд оролцсон уран бүтээлчид хүүхэд багачуудад хүндэтгэл үзүүлээ. Баяр наадмын 2 дахь орой соёлын төвд иргэдэд зориулсан Үдшийн цэнгүүн зохион байгуулж нийт 218 иргэд болон оюутан залуус хамрагдлаа.

### **ГУРАВ: ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

07 сарын 1-3-ны хооронд төсөвт байгууллагуудын 06 сарын гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч хянан баталгаажуулсан. 07 сарын 5-15 хооронд аж ахуйн нэгж болон төсөвт байгууллагуудын гүйлгээг хийж гүйцэтгэсэн. Сүхбаатар аймгийн статистикийн хэлтэст 2 улиралын мэдээ буюу Сүм хийд, төрийн бус байгууллагын мэдээ, барилга байгууламжийн мэдээ, үнийн мэдээ, мал эмнэлгийн мэдээг 7 сард багтаан цаг хугацаанд нь илгээсэн. Төсөвт байгууллагуудын 2-р улирлын тайланг гаргаж И-баланс цахим системд шивж байршууллаа. Сумын орлого төлөвлөлтийг сар бүр гаргаж гүйцэтгэлийг хангаж ажиллаж байна. Мөн Аймгийн худалдан авах газар, орон нутгийн өмчийн газраас ирсэн хяналт шалгалтын ажил материалыг бэлдэж шалгуулсан. 2023 оны орон нутгийн хөгжилийн сангаар хийгдсэн ажил үйлчилгээ болон 2024 онд хийгдсэн ажлын хяналт шалгалт, 2025 онд ОНХСангаар хийгдэх ажлыг 5 багийн иргэдээс авч сумын ажлын хэсэгт орж эрэмбэлэн цахим системд байршуулан аймгийн үнэлгээгээр 100% үнэлгээтэй байна. 25наас-30 хооронд төсөвт байгууллагын 7 сарын цалин хөлс болон тогтмол зардлуудын гүйлгээг хийж ажилласан.

### **Дөрөв : Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:**

Мал эмнэлгийн цахим системд 2 сумын 742 гарал үүслийн гэрчилгээг хянаж баталгаажуулалт хийсэн. Сумын баяр наадмаар хоол, худалдаа үйлчилгээнээс 525.0 мян төгрөг хурааж санхүү албанд тушаасан. Дуут 32 л, Сахуу 81 л вакцин

татан авч 5 мал эмнэлэгт хувиар хийсэн. Төв лабортоороос ирж шүлхий гарсан 1 өрхийн 5 үхрээс цус авч шинжилгээнд хамруулж тандалт хийсэн.

**ХАА-н чиглэлээр:** Сумын хэмжээнд улсын нөөцөөс 70 тн няцалсан буудай ирснийг нөөцийн агуулахад хураан хадгалж байна. Мөн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах 16 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХЭЗ-Н МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.